



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагчийн ажиллах түр журам батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 46 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/1723 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах болон шинэ төрлийн коронавирус /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын эрсдлийг бууруулах зорилгоор ажиллуулах олон нийтийн цагдаагийн тоог 1700-гаар нэмэгдүүлсэнтэй холбогдуулан "Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагчийн ажиллах түр журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Б.Батбямбад даалгасугай.

ДАРГА



Р.ДАГВА

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 14 нийгдрийн 59 дугаар тогтоолын хавсралт



ОЛОН НИЙТИЙН ЦАГДААГИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХОРООНЫ ХЭСГИЙН АХЛАГЧИЙН АЖИЛЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар дэлхий нийтэд тархаад буй шинэ төрлийн коронавирусын халдвар тархахаас сэргийлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллаж буй олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагчтай холбоотой харилцааг түр зохицуулна.

1.2. Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагчид олон нийтийн цагдаагийн эрх олгох, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, түүний хяналт, бүртгэлтэй холбоотой харилцааг Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан "Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэм"-ээр зохицуулна.

1.3. Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагчид олон нийтийн цагдаагийн эрх олгох ажиллагааг эрх бүхий байгууллагын харилцан зөвшилцсөнөөр хялбаршуулсан журмаар хэрэгжүүлж болно.

1.4. Энэ түр журмаар зохицуулаагүй харилцааг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 30/24 дүгээр тогтоолоор баталсан "Хорооны хэсгийн ахлагчийн ажиллах журам"-аар зохицуулна.

Хоёр. Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагчид тавигдах шаардлага

2.1. Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагч нь Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан "Олон нийтийн цагдаагийн дүрэм"-д заасан шаардлагыг хангасан байна.

Гурав. Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагчийн чиг үүрэг

3.1. Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагч нь хорооны хэсгийн ахлагчийн үндсэн чиг үүргээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1. Олон нийтийн газар, авто зам, орон сууцны орчны газар, гудамж, талбайд бие зассан, эсхүл нус, цэр, тамхины иш, хог хаях зөрчилд хяналт тавих;

3.1.2. Нийтийн зориулалттай орон сууцанд шөнийн цагаар бусад оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулж байгаа зөрчилд хяналт тавих;

3.1.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон хогийн цэгт хаяхгүй байгаа зөрчилд хяналт тавих;

3.1.4. Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах эсхүл тамхи татах боломж олгож байгаа зөрчилд хяналт тавих;



3.1.5.Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд зааснаас бусад газарт, гар дээрээс согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн зөрчилд хяналт тавих;

3.1.6.Нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3.1.7.Гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдлын талаар эрх бүхий байгууллагад мэдээлэх;

3.1.8.Иргэдэд хотын соёлыг төлөвшүүлэх.

Дөрөв. Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагчийн эрх

4.1.Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагч нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 30/24 дүгээр тогтоолоор батлагдсан "Хорооны хэсгийн ахлагчийн ажиллах журам"-д заасан эрхээс гадна Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хариуцлага тооцох эрхтэй.

4.1.1.Хариуцсан хорооны иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомжийн дагуу шаардлага тавих;

4.1.2. Ажил үүрэгтэй холбогдуулан өөрийн аюулгүй байдлыг хангуулахаар эрх бүхий байгууллагад хүсэлт гаргах;

4.1.3.Хариуцсан хорооны оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хот нийтийн аж ахуй, олон нийтийн өмчийг хамгаалах чиглэлээр хорооны Засаг даргад санал гаргаж, шийдвэрлүүлэх;

4.1.4.Албан үүргээ гүйцэтгэж байхдаа илрүүлсэн зөрчил, мэдээллийг баримтжуулах зорилгоор дуу, дүрсний бичлэг хийх, бусад техник хэрэгсэл ашиглах;

4.1.5.Чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагатай хэрэгслээр хангуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад хүсэлт тавих.

Тав. Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагчийн үүрэг

5.1.Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагч нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон дор дурдсан үүрэг хүлээнэ.


5.1.1.Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагч нь шийдвэрлэсэн зөрчлийн мэдээ, хэрэг бүртгэлтийн талаарх тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн ажилтанд тайлагнаж ажиллана;

5.1.2.Хариуцсан хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх;

5.1.3.Зөрчил шалган шийдвэрлэсэн тухай мэдээлэл, холбогдох баримтыг өдөр бүрт хорооны цагдаагийн ажилтанд хүлээлгэж өгнө.

Зургаа. Дүүрэг, хорооны Засаг даргын эрх, үүрэг

6.1.Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагчийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах.



6.2.Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагчийн өдөр тутмын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих, дэмжлэг үзүүлж ажиллах.

Долоо. Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагчийн нийгмийн баталгаа

7.1. Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагч нь энэ журмаар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд дараах баталгаагаар хангагдана.

7.1.1.Ажиллах нөхцөл бололцоогоор хангагдах;

7.1.2.Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагч нь шаардлагатай зарим хувцас хэрэгслээр хангагдах;

7.1.3.Хөдөлмөрийн хуульд заасны дагуу эзлгийн амралт эдлэх;

7.1.4.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 30/24 дүгээр тогтоолоор батлагдсан хувь хэмжээгээр урамшуулал олгоно.

7.1.5.Эрхэлсэн ажилдаа идэвхи санаачлага, үр бүтээлтэй ажилласан олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлсэн хорооны хэсгийн ахлагчид эрх бүхий байгууллагаас шагналд тодорхойлж, урамшуулж болно.

7.1.6.Мэдлэг, боловсролоо дээшлүүлэх талаарх хүсэлтээ эрх бүхий байгууллагад уламжлах;

7.1.7.Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдах.

Найм. Хариуцлага

8.1.Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагч нь энэ журмын холбогдох заалтыг зөрсөн тохиолдолд Олон нийтийн цагдаагийн эрхийг цуцлаж ажлаас чөлөөлөх хариуцлага ногдуулна.

